



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 07 өдөр

Дугаар A/186

Эрдэнэт

Улсын Онцгой комиссын
шийдвэрийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.1.5 “в”, 29.1.6 “л”, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 45, 78 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 05 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/183 дугаар тушаал, Улсын Онцгой комиссын 2021 оны 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакциныг Эрүүл мэндийн яамнаас татан авах үеийн хадгалалт, тээвэрлэлтийн горим аюулгүй байдлыг хангаж зохион байгуулахыг Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ)-т тус тус үүрэг болгосугай.

2. Коронавируст халдварын тохиолдол батлагдсан үед тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоож мэргэжлийн байгууллагын заавар зөвлөмжийн дагуу ариутгал халдваргүйтгэл хийж шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахыг Шуурхай штаб (Г.Ганбаатар)-т даалгасугай.

3.Баян-Өндөр, Жаргалант сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг диско, паб, караоке, пиво баарны үйл ажиллагааг түр зогсоосон хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийг дуустал сунгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүй дэмжлэгээр ханган, ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТЖАРГАЛ